

2024 оны 3 сар 18 өдөр

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх хэсэг, 65 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Инновэйшн Инвестмент” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Инновэйшн Инвестмент” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 551 тоот тогтоолын дагуу нийтэд санал болгон үнэт цаас гаргасантай холбогдуулан анхдугаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13:00 цагт Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Олимпийн гудамж, Шангила зочид буудлын Боллрүүм хурлын танхимд болон цахимаар зарлан хуралдуулсугай.
2. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Хавсралт №1-ийн дагуу, хурлын нийтэд хүргэх зарыг Хавсралт №2-ын дагуу, хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудсыг Хавсралт №3-ын дагуу, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох саналын хуудсыг Хавсралт №4-ийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг Хавсралт №5-ийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төслийг Хавсралт №6-ын дагуу тус тус баталсугай.
3. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн

өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн дотор Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Санхүүгийн Зохицуулах Хороонд тус тус хүргүүлсүгэй.

5. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2024 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.

6. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компанид электрон хэлбэрээр болон шуудангаар хүргүүлсүгэй.

7. Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотойгоор саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдөр нь 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 18 цаг 00 минут хүртэл байхаар тогтоосугай.

8. Хурлын даргаар Инновэйшн Инвестмент ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Д. Давааг томилсугай.

9. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

9.1. Хурал зохион байгуулах комиссын дарга:

- М.Лхамсүрэн, Гүйцэтгэх захирал, Эн Жи Интэрлэкс ХХК

9.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

- Г.Бат-Эрдэнэ, Хуульч, Өмгөөлөгч, Эн Жи Интэрлэкс ХХК

- Ш.Түвшинбаяр, Брокер, Өзлий энд Ко Капитал ҮЦК ХХК

10. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй ажиллуулахыг зөвшөөрсүгэй.

10.1. Хурлын тооллогын комиссын дарга:

- Г.Бат-Эрдэнэ, Хуульч, Өмгөөлөгч, Эн Жи Интэрлэкс ХХК

10.2. Хурлын тооллогын комиссын гишүүд:

- Г.Отгон, эрх зүйч, Эн Жи Интэрлэкс ХХК

- Ш.Түвшинбаяр, Брокер, Өзлий энд Ко Капитал ҮЦК ХХК

11. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Хурлын даргад даалгасугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Д.ДАВАА

"Иновэйшн Инвестмент" ХХК-ийн удирдах зөвлөлийн

2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн

02/05-ийн хурал №1



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар

хэлэлцэх асуудлын жагсаалт

| Хэлэлцэх асуудал | Танилцуулах |
|--|-----------------------------------|
| 1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах | Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх |
| 2. Компанийн хэлбэр өөрчлөх, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах | Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх |
| 3. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох | Гүйцэтгэх захирал Г.Эрдэнэмөнх |

“Инновэйшн Инвестмент” ХХК Төлөөлөн зөвлөлийн

2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн

02/05 тоот тогтоолын хавсралт №2



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

“Инновэйшн Инвестмент” ХХК –ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

Нэн түрүүнд “Инновэйшн Инвестмент” ХХК –ийн нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагаа (IPO) амжилттай хэрэгжиж, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 551 тоот тогтоолоор бүртгэгдэж, улмаар эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч та бүхэн тус компанийн хувьцаа эзэмшигч болсонд гүнээ талархаж буйгаа үүгээр илэрхийлье.

Ийнхүү, компани нь нийтэд санал болгон хувьцаагаа амжилттай гаргасны дараах анхдугаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр** зохион байгуулахаар төвлөсөн тул хүндэт хувьцаа эзэмшигч та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурал хуралдах өдөр, цаг: 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13 цаг 00 минут

Хурал хуралдах газар: Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Олимпийн гудамж, Шангила
зочид буудлын Боллрүүм хурлын танхимд болон цахимаар

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн хэлбэр өөрчлөх, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах
3. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгож, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох

Хуралд өөрийн биеээр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчид хурлын хэлэлцэх асуудлаар гарах шийдвэрийн төсөлд өгөх саналаа 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 18 цаг 00 минут дотор саналын хуудсаар ирүүлнэ үү.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар:

Санал өгөх хувьцааны тоо:

Инновэйшн Инвестмент ХХК-ын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүтээр сарын 28-ны өдрийн 13:00 цагт танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

Санамж:

Та зөвхөн өөрийн дэмжиж буй саналын урд байгаа сонголтыг тэмдэглэгээгээр тэмдэглэснээр саналаа өгөхийг анхаарна уу.

| Д/д | Шийдвэрлэх асуудал | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|-----|---|--------------------------|--------------------------|--------------------------|
| 1. | Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлана | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |
| 2. | Компанийн хэлбэр өөрчилж, Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлана | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> | <input type="checkbox"/> |

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, тайлал _____ / _____

Бүртгэсэн (үнэт цаасны компани) _____

Саналын хуудсыг хүлээн авсан эрх бүхий этгээдийн гарын үсэг, тайлал: _____ / _____

САНАЛЫН ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ:

Тайлбар / Санамж:

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт () эсхүл бусад тэмдэглэгээг тэмдэглэнэ үү. Таны санал шийдвэрлэх асуудал бүрээр бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор үржигдэж тооцогдоно.0
2. Та саналаа урьдчилан заасан хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, элчингийн гудамж, Шүрэн оффис, 1 давхар, 6 тоот Компанийн байранд саналын хуудсаар саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд таны санал хүчинтэйд тооцогдоно.
4. Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол саналын хуудас хүчингүйд тооцогдоно.

.....

Энэ хэсгийг санал хураалтын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм / Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: _____



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

Компанийн нэр “Инновэйшн Инвестмент” ХХК

Хурал хуралдах газар, өдөр, цаг: 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр 13:00 цагт

Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Олимпийн гудамж,
Шангила зочид буудлын Боллрүүм хурлын танхимд болон
цахимаар.

Хувьцаа эзэмшигчийн нэр:

Регистрийн дугаар:

Хаяг:

Холбоо барих:

Эзэмшиж буй хувьцааны тоо:

Инновэйшн Инвестмент ХХК-ын Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 13:00 цагт танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана.

Санал хураах арга: **Кумулятив**

Санал хураах кумулятив аргыг хэрэглэх тухай тайлбар:

- Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна.
- Хувьцаа эзэмшигч нь саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нь 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Компанийн дүрмээр тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон. Хувьцаа эзэмшигч А-ийн эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100*9 гишүүн=900/ болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч нь нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч нь саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд нэр дэвшигчийг сонгох

Саналын эрхтэй хувьцааны тоо -

| № | Нэр дэвшигчийн овог, нэр | Саналын тоо |
|----|--------------------------|-------------|
| 1. | | |
| 2. | | |
| 3. | | |
| 4. | | |
| 5. | | |
| 6. | | |

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийг сонгох

Саналын эрхтэй хувьцааны тоо-

| № | Нэр дэвшигчийн овог, нэр | Саналын тоо |
|----|--------------------------|-------------|
| 1. | | |
| 2. | | |
| 3. | | |

| |
|---|
| Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг Овог нэр: Гарын үсэг: |
| Хувьцаа эзэмшигчийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бөглөх хэсэг Овог нэр: Гарын үсэг: |
| Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг: |
| Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг: |

САНАЛЫН ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ:

Тайлбар / Санамж:

4. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт () эсхүл бусад тэмдэглэгээг тэмдэглэнэ үү. Таны санал шийдвэрлэх асуудал бүрээр бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор үржигдэж тооцогдоно.
5. Та саналаа урьдчилан заасан хугацаанд брокер, дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, элчингийн гудамж, Шүрэн оффис, 1 давхар, 6 тоот Компанийн байранд саналын хуудсаар саналаа өгнө.
6. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг авчран саналын хамт өгсөн тохиолдолд таны санал хүчинтэйд тооцогдоно.
7. Засварласан, балласан, тэмдэглэгээг буруу үйлдсэн бол саналын хуудас хүчингүйд тооцогдоно.

.....

Энэ хэсгийг санал хураалтын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм / Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: _____

“Инновэйшн Инвестмент” ХХК Төлөөлөн удирдах зөвлөлийн



2024 оны 03 саргаар сарын 18-ны өдрийн

04/05 тоот тогтоолын хавсралт №5

Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт

- “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан
- “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан
- “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулсан аудитын дүгнэлт
- “Инновэйшн Инвестмент” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг бүртгэхийг зөвшөөрсөн Санхүүгийн зохицуулах хорооны 2023/11/08-ны өдрийн 551 тоот тогтоолын хуулбар
- “Инновэйшн Инвестмент” ХК-ийн дүрмийн төсөл
- “Инновэйшн Инвестмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшүүлсэн этгээдийн материал
- Хувьцаа эзэмшигчдийн хуралд цахимаар оролцох гарын авлага, зааварчилгаа



“Инновэйшн Инвестмент” ХХК Төлөөлөн удирдах зөвлөлийн

2024 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн

02/05 тоот тогтоолын Хавсралт №6

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл (1)

“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ /төсөл/

2024 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 40 дүгээр зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “Инновэйшн Инвестмент” ХХК /цаашид “Компани” гэх/-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийн дагуу энэхүү тогтоолын Хавсралт.№1-т заасны дагуу Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг, Хавсралт.№2-т заасны дагуу Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталсугай.
2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг, аудитын дүгнэлтийн хамт тус тус Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх ажлыг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэмөнх/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА: _____ /Д.ДАВАА /

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл (2)

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ
/төсөл/**

2024 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.9 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, “Инновэйшн инвестмент” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн, Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдааны 551 тоот тогтоолоор үнэт цаасаа бүртгүүлж, хувьцаагаа нийтэд санал болгон худалдах ажиллагааг амжилттай хэрэгжүүлсэн болохыг дурдсугай.
2. Үүнтэй холбогдуулан, компанийн хэлбэрийг “Инновэйшн инвестмент” ХК болгон өөрчлөхөөр шийдвэрлэсүгэй.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Компанийн дүрмийг Хавсралт №1-ийн дагуу шинэчлэн баталсугай.
4. Компанийн мэдээлэлд орсон өөрчлөлтийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Санхүүгийн зохицуулах хороо болон хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх, баримт бичиг хүргэх, хүлээн авах эрхийг С.Гүржав /РД: ТБ81112013/-д итгэмжлэн олгосугай.

ХУРЛЫН ДАРГА: _____ /Д.ДАВАА /

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл (3)

**“ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ” ХХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ
/төсөл/**

2024 оны 04 сарын 28-ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, шинээр төлөөлөн
удирдах зөвлөлийн гишүүн томилох тухай**

Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 62.1.16 дахь заалт, 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, “Иновэйшн Инвестмент” ХХК-ийн дүрмийн холбогдох хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгож, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр дараах хүмүүсийг томилсугай:
 - 1.1. /РД:/-г - ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - 1.2. /РД:/-г -ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - 1.3. /РД:/-г -ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - 1.4. /РД:/-г -ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - 1.5. /РД:/-г -ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - 1.6. /РД:/-г -ТУЗ-ийн ердийн гишүүнээр;
 - 1.7. /РД:/-г -ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
 - 1.8. /РД:/-г -ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
 - 1.9. /РД:/-г -ТУЗ-ийн хараат бус гишүүнээр;
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн бирж болон улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал /Г.Эрдэнэманх/-д үүрэг болгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөл томилогдсонтой холбоотойгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаа сонгох, компанийн үйл ажиллагааг Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд заасан бүрэн эрхийн хүрээнд үр ашигтай бөгөөд зохистойгоор удирдан явуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА: _____ /Д.ДАВАА /